



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо,
Бага тойруу-3, Ц.Жигжиджавын гудамж-9,
Нийслэлийн засаг захиргааны II байр, Хангарди ордон
Утас/Факс: (976-11) 32-50-76
E-mail: ubhd@emg.ub.gov.mn, http://www.ubhealth.mn

2019.01.30 № 1/79
таний _____ -ны № _____ -т

ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ,
НЭГДСЭН ЭМНЭЛЭГИЙН
ДАРГА НАРТ

Г Албан даалгавар хүргүүлэх тухай

Томуу, томуу төст өвчний идэвхжил, дэгдэлтийн үеийн эмнэлгийн тусlamж, үйлчилгээг шуурхай зохион байгуулах, халдвартын сэргийлэлт, хяналтыг сайжруулах, мэдээлэл, сургалт, сурталчилгааны арга хэмжээг эрчимтэй зохион байгуулах талаар гарсан Эрүүл мэндийн сайдын 2019 оны "Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед авах зарим арга хэмжээний тухай" 08 дугаар албан даалгаврыг хавсралтаар хүргүүлж байна.

Мөн тус албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн яаралтай тусламжийн тасгаар үзүүлж байгаа өвчтөний амьсгалын замын цочмог халдвартын улмаас анх удаа буюу бусад эрүүл мэндийн байгууллагад хандаагүй тохиолдлыг томуу, томуу төст өвчний долоо хоногийн мэдээнд оруулж, дүүргийн эрүүл мэндийн төвийн статистик, бүртгэл мэдээлэл хариуцсан эмчид хүргүүлэх болсныг мэдэгдэж байна.

Түүнчлэн албан даалгаврын хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээг 7 хоног тутмын Мягмар гарагийн 12:00 цагт цахим (batarsuh2230@gmail.com) хаягаар ирүүлнэ үү.

Хавсралт: хуудастай.

Хувийг: Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоонд

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

1150500034



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2019 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Г Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед
авах зарим арга хэмжээний тухай

Томуу, томуу төст өвчин тархвар судлалын 2 дугаар /1дүүзээр сарын 7-14/ долоо хоногт улсын хэмжээнд амбулаторийн үзлэгийн 10,6 хувийг эзэлж байгаа хэдий ч хүүхдийн орны ачаалал хэтэрч, хэвтэлт өндөр байгаа нь томуугийн А дэд хэвшинжийн H1N1 вирус зонхилон орчиж цаашид нэмэгдэх хандлагатай байна.

Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеийн эмнэлгийн тусlamж үйлчилгээг шуурхай зохион байгуулах, халдварт хамгааллын дэглэмийг баримтлах, мэдээлэл, сургалт, сурталчилгааны арга хэмжээг эрчимтэй зохион байгуулахыг төрөлжсөн мэргэшлийн төв, тусгай мэргэжлийн эмнэлэг, тусгай эмнэлэг, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, хувийн болон холимог өмчйт эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт ДААЛГАСУГАЙ.

1. Тандалт, зохицуулалтын талаар:

1.1 Яаралтай тусlamжийн тасгаар үзүүлж байгаа өвчтөний тоог томуу, томуу төст өвчний долоо хоногийн мэдээнд оруулах;

1.2 Аймаг, дүүргийн эмнэлгийн дэргэд ӨЭМТ-ийн эмч нарыг зуваарийн дагуу ажиллуулан үзлэгийн тоог тухайн эмнэлгийн амбулаторийн үзлэгийн мэдээнд оруулах;

1.3 Амьсгалын цочмог халдварт тархалтаас сэргийлж, амбулаторийн үзлэгийн кабинет, яаралтай тусlamжийн тасагт ирж буй иргэд, тасагт хэвтэч эмчлүүлж буй өвчтөн, сахиурт амны хаалт тогтмол зүүлгэж хэвшүүлэх, хяналт тави;

1.4 Эмч, ажилчид, үйлчлүүлэгч, сахиуруудад гар халдвартгүйж үлэх уусмалыг тогтмол хэрэглүүлэх.

2. Эмнэлгийн тусlamж үйлчилгээг үзүүлэх талаар:

2.1 Томуу, томуу төст өвчний тархалтын үед баримтлах оношилгоо эмчилгээний заавар зөвлөмжийг мөрдөж ажиллах;

2.2 Тусlamж, үйлчилгээний урсгал хөдөлгөөнийг зохицуулан сүнд өвчтөнийг харьяалал харгалзахгүй хэвтүүлэн эмчлүүлэх;

2.3 Өрхийн эрүүл мэндийн төвийн тусlamж үйлчилгээг гэрийн эргэлтэд шилжүүлэх;

2.4 Эмнэлгийн яаралтай тусlamжийн тасгаар үзүүлээд буцсан, эмнэлэгт эмчлүүлэн гарсан хүүхдүүдийн мэдээллийг өдөр бүр ӨЭМТ-үүд аван хяналт, эргэлтийг сайжруулах;

2.5. Амьсгалын замын цочмог халдвартын улмаас эмнэлэгт эмчлүүлээд гарсан эрсдэлт бүлгийн хүүхдийг тухайн орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамtran, харьяа сувилал, амраалтын газарт түр байрлуулан эргэн хэвтэлтээс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;

2.6 Эрчимт эмчилгээний амьсгалын аппаратын үйл ажиллагааг тогтмол шалган, хяналт тавих;

2.7 Амьсгалын зам саадтай, хүчилтөрөгчийн хэрэгцээтэй өвчтөнийг 2 цаг тутамд пульсоксиметрээр хэмжиж, хяналтыг тогтмолжуулах, хүчилтөрөгч эмчилгээг тасралтгүй хийх нөхцөл бүрдүүлэх;

2.8 Дүүргийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эрчимт эмчилгээний тасагт телемидицинийг ашиглан ЭХЭМҮТ-өөс зөвлөгөө авах боломж бүрдүүлэх;

2.9 Эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, шаардлагатай эмийн нөөц бүрдүүлэх;

2.10 Анагаах ухааны чиглэлийн их, дээд сургуулийн төгсөх ангийн оюутнууд, ахмад эмч, сувилагч нарыг богино хугацааны хурдавчилсан сургалтад хамруулж, хүүхдийн тусламж үйлчилгээнд ажиллуулах.

3. Мэдээлэл сургалт сурталчилгааны талаар:

3.1 Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг томуу, томуу төст өвчний эргэн мэдээллээр хангах;

3.2 “Томуу, томуу төст өвчний халдвараас сэргийлье” мэдээлэл, сурталчилгааг иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, орон нутгийн төрийн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамtran хэвлэл мэдээллийн бүх хэрэгслийг ашиглан тогтмол зохион байгуулах;

3.3 Ханиад, томуугийн дэгдэлтийн үед Монголын уламжлалт анагаах ухааны ололтыг ашиглан урьдчилан сэргийлэх, дархлаа дэмжих, эмчилгээний үр дүнг батжуулахад чиглэгдсэн заавар, зөвлөмж иргэдэд хүргэх.

4. Албан даалгаврын хэрэгжилтийг 14 хоног тутмын Пүрэв гарагийн 12:00 цагт Халдварт өвчин судлалын үндэсний төвийн /ХӨСҮТ/ Томуутийн тандалтын нэгжид ирүүлэх.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ

